



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД

2021.09.16 № 03/2108
танай _____-ны № _____-т

Шинжээч сонгон шалгаруулах
зар хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд “Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж буй өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөнгөлөлтийн тооцоолол, хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлэх” зорилгоор шинжээч сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж буй өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг хөнгөлөх тооцоолол, олгосон санхүүжилтийн үр дүнд судалгаа, тооцоолол хийж, дүгнэлт гаргах судалгаа шинжилгээний ажил хийсэн туршлагатай, эм зүйн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц бүхий шинжээчийн баг, хуулийн этгээдийг аудитад шинжээчээр ажиллуулах шаардлага үүссэн бөгөөд шинжээч нь тус зөвлөх үйлчилгээг 2 хүртэл сарын хугацаанд гүйцэтгэх ба дараах ажилбаруудыг хэрэгжүүлж, аудитын талбарын болон тайлагналын үе шатны үйл ажиллагаанд шаардлагатай мэргэжлийн, шинжлэх ухааны үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. Үүнд:

- Өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг оновчтой тодорхойлж, үнийн хөнгөлөх хэмжээг бодитой тооцсон эсэхэд дүн шинжилгээ хийх, санал боловсруулж, дүгнэлт, тайлан, зөвлөмж гаргах;
- Өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхдээ эдийн засгийн бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, санхүүжүүлсэн эсэхэд дүн шинжилгээ хийх, санал боловсруулж, дүгнэлт, тайлан, зөвлөмж гаргах;
- Өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх өнөөгийн тогтолцоо, явуулж буй бодлого, үйл ажиллагаа хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, санал боловсруулж, дүгнэлт, тайлан, зөвлөмж гаргах;
- Өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас

санхүүжүүлсэн хөрөнгийн үр дүн, үр ашиг, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх, санал боловсруулж, дүгнэлт, тайлан, зөвлөмж гаргах зэрэг болно.

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичиж, гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Иймд мэдээллээ ирүүлж буй зөвлөх шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн албан хүсэлт ирүүлэхээс гадна дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын өргүй тухай тодорхойлолт/;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тодорхойлолт/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний 2018,2019,2020 оны мэдээлэл;
- Ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/;
- Сүүлийн 2 жил /2019, 2021 он/-ийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлт.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Анкет /CV/;
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/;
- Багийн гишүүдийн хамтран ажиллах гэрээ /нотариатаар баталгаажуулсан/;

Шинжээч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, эм зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийгэмлэг, холбоод, төрийн бус байгууллагууд болон эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч, борлуулагч, бусад хамаарал бүхий этгээдээс гэрээт ажил үүрэгт нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байж, гэрээгээр хүлээсэн үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага: Үүнд:

Хуулийн этгээд (түншлэл)-ийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх;
- Эрүүл мэнд, эм зүйн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт гаргасан туршлагатай байх;
- Төрөөс эмийн талаар гаргаж байсан бодлогын хэрэгжилт, өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс үзүүлж байгаа дэмжлэг, түүний санхүүгийн тооцоолол, үндэслэл, төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж, дотоодын болон олон улсын байгууллагатай хамтран тус чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэсэн туршлагатай байх;
- Эм зүйн шинжлэх ухааны эмийн эдийн засаг, маркетинг, эмийн чанар, аюулгүй байдал, эмнэл зүйн эм зүй, эмийн зохистой хэрэглээний талаар судалгаа, шинжилгээ хийх 3-аас дээш хүний нөөцтэй байх.

Ажиллах хүчний шаардлага:

- Эм зүйн шинжлэх ухааны эмийн эдийн засаг, маркетинг, эмийн чанар, аюулгүй байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх 3-аас дээш эрдэмтэн судлаачтай;
- Өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын тооцоолол, төлөвлөлтийн үндэслэл, хөнгөлөлт, чөлөөлөлтийн тооцоололд санхүүгийн дүн шинжилгээ хийх мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;
- Өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийн талаар судалгаа хийж, дүн шинжилгээ хийх мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх.

Багийн хувьд:

- Багийн ахлагч болон гишүүд нь эрүүл мэндийн салбарт 5, түүнээс дээш жил ажилласан тухайн чиглэлээр нарийн мэргэшсэн, магистр болон түүнээс дээш боловсролын зэрэг, цолтой, эрүүл мэнд, эмзүй, эмнэл зүйн шинжээч, санхүүгийн шинжилгээ, судалгаа хийдэг, судлаач, эрдэмтэн, эрдэм шинжилгээний чиглэлээр мэргэшсэн байх;
- Хуулийн этгээдийн ажиллах хүчний дадлага туршлагын үзүүлэлттэй дүйх хэмжээний дадлага туршлагатай гишүүдтэй байхаас гадна англи хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
- Судалгааны багийн ахлагч болон гишүүд нь эм зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, гишүүддээ үйлчилдэг нийгэмлэг, холбоодын гишүүнчлэлгүй байх;
- Судалгааны багийн ахлагч болон гишүүд нь эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлдэггүй, тэдний ашиг сонирхол, нөлөөлөлд автахгүй байх.

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.


Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба Түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 17 цаг 00 минутаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 09 цаг 00 минутын дотор цахим /pdf файл/ хэлбэрээр дараах хаягаар илгээнэ үү.

Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068. Хугацаа хоцроосон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр, Үндэсний аудитын газар,
Утас: 51-263533. www.audit.mn

ТАМГЫН ДАРГА



Ц.ГАНБОЛД